

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АВЛИГЫН ЭСРЭГ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2017 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

2018.01.05 Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.10.1: 4.1.1.10: 		
1	<p>1.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах мэдээллийгиргэд,байгууллага чөлөөтэйавах нөхцөлийг хангах,</p>	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах мэдээллийгиргэд,байгууллага чөлөөтэйавах нөхцөлийг хангаж мэдээллийг нийтэд түгээх, төрийн байгууллага, оюутан сурагч, эрдэмтэн судлаачдад хүргэх зорилгоор www.mta.mn сайтны статистик мэдээний буланг улирал тутам шинэчлэж, нийт 16 төрлийн статистик мэдээллийг 3 удаагийн давтамжтай байршуулав.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах Татвар төлөгчдийн татварын боловсролыг дээшлүүлэх, улмаар татвар үнэн зөв хугацаанд тайлагнаж, төлөхөд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор 3 удаагийн сургалтын удирдамжийг баталж, татварын албадад хүргүүлэн хэрэгжүүлэв.</p> <p>Татварын ерөнхий газарт болон татвар төлөгчийн ажлын байран дахь сургалтыг нийт 7 удаа хийж 1189 татвар төлөгчийг хамруулав.</p>
	<p>1.2.Авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагчдад хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалтыг цахим болон танхимын сургалтын хөтөлбөрт тусган зохион байгуулах</p>	<p>Авлигатай тэмцэх газарт 2017 оны 01 дүгээр сарын 06-ний 03/45 дугаар албан бичгээр Татварын албаны ЭБАТ нарт сургалт авах хүсэлтийг хүргүүлсэн. Хүсэлтийн хүлээн авч Авлигатай тэмцэх газраас 2017 оны 01 дүгээр сарын 17-18 өдрүүдэд зохион байгуулсан сургалтад ТЕГ, УТОХГ, НТГ, БГД, БЗД, ХУД, СХД, ЧД-ийн Татварын албадын 8 ЭБАТ-ыг хамрагдав. Сургалтаар өгсөн заавар чиглэлийг Орон нутгийн татварын албадад 2017 оны 01 дүгээр сарын 19-ны 03/199 дүгээр албан бичгээр, сургалтын материалын хамт файлаар хүргүүлэв.</p> <p>Мөн Авлигатай тэмцэх газарт 2017 оны 01 дүгээр сарын 30-ний 03/310 дугаар албан бичгээр Татварын албаны удирдах албан тушаалтны сургалт семинарт зориулан Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт авах хүсэлтийг хүргүүлэв. Хүсэлтийг хүлээн авч Авлигатай тэмцэх газраас 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Татварын албаны удирдах албан тушаалтан нарт сургалт хийв.</p> <p>Татварын албаны ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадавхийг дээшлүүлэх чиглэлээр “Татварын</p>

		<p>албаны ажилтан, албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр"-ийг ТЕГ-ын даргын 2017 оны А/11 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлэх ажлын зохион байгуулав.</p> <p>Мэргэшүүлэх, хураагчийн болон эрх олгох, ажлын байрны чиг үүргийн талаарх сургалтын цахим болон танхимын сургалтын хөтөлбөрт Авлига, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрб цагийн сургалтыг тусгаж татварын албаны албан хаагчдад хийв. Үүнд:</p> <p>Мэргэшүүлэх сургалтыг Хөвсгөл, Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Төв, Дорнод, Өмнөговь, Хэнтий, Говьсүмбэр, Ховд аймгийн татварын хэлтсийн татварын улсын /ахлах/ цахим хэлбэрээр 30 хоног, танхимын сургалтад 3 өдөр зохион байгууллаа. Сургалтад 272 татварын улсын /ахлах/ байцаагч хамрагдав. Мөн дээрх сургалтад УТОХГ, НТГ, Нийслэл дүүргийн татварын газар, хэлтсийн 582 татварын улсын /ахлах/ байцаагчид хамрагдсан болно.</p> <p>Татвар хураагчид зориулсан сургалтыг цахим хэлбэрээр 3 удаа, танхимаар 1 удаа зохион байгуулсан. Цахим сургалтад 220 хураагч хамрагдсан.</p> <p>Татварын улсын байцаагчийн эрх олгох сургалтад 147 татвар хураагч хамрагдав.</p> <p>Татварын улсын байцаагчийг шилүүлэх, сэлгэн ажиллуулахтай холбогдуулан ажлын байрны чиг үүргийн талаарх сургалтад 11 албан хаагчийг хамрууллаа.</p>
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.4: 		
2	<p>2.1.Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг иргэд, олон нийт, сонирхогч бүлэгт мэдэгдэх, санал авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх</p>	<p>Татварын ерөнхий хууль, ААНОАТ, ХХОАТ-ын тухай, Хөрөнгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн төслүүдийг боловсруулж Сангийн яаманд 2017 оны 3 сарын 27-ны өдөр хүргүүллээ. Хуулийн төслийг боловсруулахдаа Англи, Австрали, Америк, БНСУ гэх мэт 12 улсын туршлагыг судлах, ОУВС-ын Техникийн туслалцааны баг, ЖАЙКА-гийн төслийн зөвлөхүүдээс зөвлөгөө авах, Сангийн яам, ТЕГ-ын зохион байгуулалтын нэгж, татварын албад төслийг хүргүүлж санал авах, удаа дараа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан болно. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар Татварын хоёр дахь шатны шинэчлэл хийх, Монгол Улсын Засгийн газар, ОУВС хооронд тохирсон өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд уг ажлын хүрээнд Татварын ерөнхий хууль, ААНОАТ болон ХХОАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Сангийн яаманд дахин хүргүүлсэн.</p> <p>Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, үзэл баримтлал, хэрэгцээ шаардлагын судалгаанд шаардагдах судалгаа, мэдээллийг тухай бүр Сангийн яаманд хүргүүлэн, хамтран ажилласан. Хуулийн төслүүдийг 2018 оны эхээр УИХ-д хүргүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Шинэчлэн боловсруулсан татварын хуулийн төслүүдтэй холбоотой Аудитын компаниуд, ТИНЗ нийгэмлэг, татварын зөвлөх үйлчилгээний компаниудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг Сангийн яамны ТБТГ-тай хамтран 2 удаа</p>

		зохион байгуулав.
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3: • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.1: 4.1.2.4: 		
3	<p>3.1.Татварын үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах</p>	<p>Татварын хуучин мэдээллийн систем, түүний дэд бүтэц, сүлжээ, өгөгдлийн сан, програм хангамжийг буцааж хүлээн авч хуримтлагдсан асуудлуудыг бүрэн шийдэж чадсан. Татварын албаны мэдээллийн Тахаст систем, түүний өгөгдлийн сангийн нэгтгэлийн Replication, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн өгөгдлийн Normal систем, төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох Data sharing систем, татвар төлөгчийн бүртгэлийн Trips систем, татвар төлөгчийн хөндлөнгийн мэдээллийн Tri систем, татварын хяналт шалгалтын Fisher систем, автотээврийн хэрэгслийн албан татварын мэдээллийн Autotax систем, цахим тайлан e-tax системийн хуулбар өгөгдлийн сан, татварын өгөгдлийн data warehouse систем, ухаалаг тайлангийн BI систем, уул уурхайн Mining систем, татвар төлөгчийн лавлагаа тодорхойлолтын зэрэг системүүдийн тасралтгүй найдвартай үйл ажиллагаа, мэдээллийн үнэн зөв байдал, мэдээллийн сангийн нууцлал аюулгүй байдлыг хангаж ажилсан.</p> <p>Татварын ерөнхий газрын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд судалгааг хийж ABLE системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. ABLE системийг Татварын ерөнхий газрын дотоод бүтцийн нэгжүүд, УТОХГ-н нийт 250 гаруй албан хаагчдын хэрэглээнд нэвтрүүлэн үйл ажиллагааг цахимжуулсан байна</p> <p>Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах хүсэлтэй иргэдээс Татварын албанд бүрдүүлэн ирүүлэх бичиг баримтын тоог багасгаж, зарим баримт бичгийг төрийн мэдээлэл солилцооны системээс авахаар шийдвэрлүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүндрэлгүй хүргэх үүднээс Үндэсний дата төвтэй хамтран "ХУР" системийн ашиглахаар хэрэглэгчийн платформыг хөгжүүлсэн.</p> <p>Татварын байгууллагын үйлчлүүлэгчдээс авах сэтгэл ханамжийн судалгааг татварын цахим тайлангийн системээр дамжуулан авахад 117'152 татвар төлөгч саналаа ирүүлсэн байна. Хэрэглэгчийн үнэлгээ буюу Татвар төлөгчийн сэтгэл ханамжийн судалгааны асуулгын загварыг 9 бүлэг 23 асуулттайгаар боловсруулж, нэг цэгээр үйлчлүүлж буй татвар төлөгчдөөс утсаар, цахимаар тус тус авч байна.</p>
	<p>3.2.Татвар эрсдэлээс сэргийлэх эрсдэлд хяналт зохион хяналтын төлөгчийг урьдчилсан зорилгоор суурилсан шалгалтыг байгуулах, үйл</p>	<p>ТЕГ-ын даргын 2017 оны А/46 дугаар тушаалаар "Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам", "Эрсдэлийн удирдлагын хорооны хурлын дэг"-ийг, А/47 тушаалаар "Хяналт шалгалтын үр дүнд эрсдэлийн шинжилгээ хийх заавар"-ыг, А/65 дугаар тушаалаар Татварын албаны 2017 оны эрсдэлд суурилсан татвар төлөгчийн сегмент бүрээр ангилсан татварын хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг, А/78 дугаар тушаалаар НТГ-ын 2017 оны эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтын төлөвлөгөөг, А/109 дугаар тушаалаар татварын хяналт шалгалтад хамруулах эрсдэл бүхий татвар төлөгчийн жагсаалт, нэмэгдэх, хасагдах төлөвлөгөөний нэгтгэлийн өөрчлөлтийг, А/146 дугаар тушаалаар Татварын ерөнхий газрын харьяа нэгжийн</p>

ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах	<p>үйл ажиллагаанд дотоод эрсдэл тооцох заавар, шалгуур үзүүлэлтийг тус тус батлан хэрэгжүүлээ.</p> <p>Татварын албаны хэмжээгээр 2017 оны 1-9 сард 2523 татвар төлөгчийг татварын хяналт шалгалтад хамруулахаас 2827 татвар төлөгчийг хамруулж, 1696.3 тэрбум төгрөгийн зөрчилд 116.5 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулсан байна. Үүнээс татварын хяналт шалгалтын батлагдсан төлөвлөгөөгөөр 1220 татвар төлөгч шалгах аас 1524 татвар төлөгчийг шалгаж 938.8 тэрбум төгрөгийн зөрчилд 49.1 тэрбум төгрөгийн төлбөр, бусад байгууллагын хүсэлт шийдвэрээр 1303 татвар төлөгчийг шалгаж 757.5 тэрбум төгрөгийн зөрчилд 67.5 тэрбум төгрөгийн төлбөрийг тус тус ногдуулсан байна.</p>
---	--

Эрх зүйн үндэслэл:

- Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.3.3:

4 Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	4.1. Тухайн жилийн төсөв	Татварын албаны хэмжээнд 2017 онд батлагдсан 30,5 сая төгрөгийн төсвийг татварын харъяа аймаг, дүүргийн татварын хэлтсүүдэд хуваарилж, төсвийн зарцуулалтад хяналт тавьж шилэн данс, mta.gov.mn болон санхүүгийн ил тод байдлын самбарт байршуулсан.
	4.2. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл	Татварын ерөнхий газрын 2016 оны батлагдсан төсөв 3,493.5 сая төгрөг, гүйцэтгэл 2,893.5 сая төгрөг байна.
	4.3. Сарын төсвийн гүйцэтгэл	2017 оны 12-р сард 2,201.5 сая төгрөг батлагдсан төсөвтэйгээс 2,007.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг shilendans.gov.mn, санхүүгийн ил тод самбарт байршуулж ажилласан.
	4.4. Улирлын төсвийн гүйцэтгэл	Улирлын төсвийн гүйцэтгэлийг shilendans.gov.mn-д тухай бүр байршуулан ажиллаж байна.
	4.5. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл	Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг shilendans.gov.mn, санхүүгийн ил тод самбарт байршуулж ажилласан. 2017 оны эхний хагас жилийн батлагдсан төсөв 3,717.5 сая төгрөг, гүйцэтгэл 3,039.1 сая төгрөг буюу 678.4 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.
	4.6. Хагас жилийн санхүүгийн тайлан	2017 оны хагас жилийн санхүүгийн тайланг УСНББОУС-ын дагуу санхүүгийн Emerald программаар бэлтгэн гаргаж mof.gov.mn, shilendans.gov.mn, санхүүгийн ил тод самбарт байршуулж ажилласан
	4.7. Дараа жилийн төсвийн төсөл	2019 оны төсвийн төсөл хүргүүлэх хугацаа болоогүй байгаа болно.

			<p>2017 оны жилийн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлдэг тул хугацаа болоогүй байгаа болно.</p>
		<p>4.8. Жилийн эцсийн санхүүгийн тайлан</p>	
		<p>4.9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт</p>	<p>ҮАГ-аас Татварын Ерөнхий газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна гэж “Зөрчилгүй” дүгнэлт өгч, 5 зөвлөмж ирүүлсэн байна.</p>
		<p>4.10. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</p>	<p>ҮАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу УСНББОУС-6 нэгтгэсэн санхүүгийн тайлан 45,46-д “ЭЗНБ-н хүрээнд багтах байгууллагуудын хоорондын дансны үлдэгдэл, ажил гүйлгээ, орлого болон зардлыг бүрэн устгах” гэсэн заалтын дагуу ажил гүйлгээ, орлого болон зардлыг бүрэн устгаж, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан төсөвт байгууллагын "Санхүүгийн тайланг бэлтгэх заавар" болон бусад холбогдох дүрэм зааврыг баримтлан ажиллаж байна.</p>
		<p>4.11. Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар</p>	<p>2017 оны батлагдсан төсвөөс тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллаас 89.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 34,8 сая төгрөг хэмнэгдсэн байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас хэмнэгдсэн шалтгаан нь Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн 1 м² түрээсийн зардлыг шинэчлэж гэрээ байгуулсантай холбогдон хэмнэгдсэн зардал болно.</p>
		<p>4.12. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт</p>	<p>Татварын албадын 2017 оны үйл ажиллагаанд дутагдаж буй урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн судалгаа тооцоог гарган ТЕГ-ын удирдлагад танилцуулан Сангийн сайд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төсвийн бодлого төлөвлөлтийн газар, Төрийн захиргааны удирдлагын газар, Төрийн сангийн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт албан бичгээр хүсэлт хүргүүлж ажилласан ба урсгал төсвийн Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 276.0 сая, Нормын хувцас, зөөлөн эдлэл</p>

		худалдан авах зардлыг 60.0 сая, Урсгал засварын зардлыг 250.0 сая төгрөг, тус тус нэмэгдүүлж тодотгуулан өр нэмж үүсэхгүй байх, татварын албадын үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлэн ажилласан ба 2017 оны төсвийн тодотголоор 11-р сард батлагдсан хөрөнгө оруулалтын 1,500.0 сая төгрөгийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан.
	4.13. Төсвийн татварын орлогын мэдээг нээлттэй болгох	<p>УИХ болон Аймаг, Нийслэлийн Иргэдийн Хурлын тогтоолоор Татварын алба 2017 онд улс, орон нутгийн төсөвт нийт 3259.2 тэрбум төгрөг, улсын төсөвт 2318.5 тэрбум, орон нутгийн төсөвт 940.7 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээр баталсан. Улсын төсөвт 2017 онд төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөөний хуваарийг ТЕГ-ын даргын 2017 оны А/19, А/106 оны дугаар тушаалаар батлан татварын албадад хүргүүллээ. Төлөвлөгөө боловсруулахдаа татварын албадын сүүлийн 3 жилийн татварын ногдуулалт, төлөлтийн судалгаа, урьд оны татварын өрийн үлдэгдэл, зарим татварын хуульд орсон хувь хэмжээний өөрчлөлт, дэлхийн эдийн засаг болон хөрш орнуудын эдийн засгийн талаар бусад эх сурвалжаас гаргасан судалгаа, Монгол Улсын Их Хурлаас баталсан төсвийн хүрээний мэдэгдэл, макро эдийн засгийн үзүүлэлтүүдтэй уялдуулсан болно. Улсын төсвийн 2017 оны төлөвлөгөө урьд оны төлөвлөгөөнөөс 928.4 тэрбум төгрөг буюу 66.8 хувиар, гүйцэтгэлээс 738.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.</p> <p>Орон нутгийн ИТХ-аас 2017 онд 940.7 тэрбум төгрөг Орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө урьд оны гүйцэтгэлээс 112.7 тэрбум төгрөг буюу 13.6 хувиар, төлөвлөгөөнөөс 142.5 тэрбум төгрөг буюу 17.9 хувиар тус тус өссөн байна.</p>
	4.14. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт shilendans.gov.mn тогтмол байршуулсан.
	4.15.Байгууллагын	ТЗУГ

		<p>батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт</p>	<p>Сангийн сайдын 2017 оны 9 сарын 05-ны 290 дүгээр тушаалаар ТЕГ-ын үйл ажиллагааны стратеги зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан. Үүгээр Хуулийн хэлтсийг Хуулийн хэрэгжилтийг хангах газар болгон өөрчилж, шинээр 20 орон тоог нэмж баталсан.</p>
		<p>4.16.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт /тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт/-ыг цахим хуудсандаа байршуулах</p>	<p>Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээд дарга, нягтлан нарын мэдээллийг шилэн дансанд байршуулсан.</p>
		<p>4.17. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл</p>	<p><u>1.Олон Улсын Валютын сан /ОУВС/ АНУ-ын Төрийн сангийн шугамаар санхүүжүүлж буй “Татварын удирдлагын шинэчлэлт” төслийн хүрээнд:</u></p> <p>Татварын ерөнхий газар ба ОУВС-ын Төсвийн асуудал эрхлэх газар хоорондын хамтран ажиллах санамж бичиг”, төсөл болон холбогдох суурь баримт бичгийг боловсруулж, 2017 оны 2 сарын 9-ний өдөр Санамж бичигт гарын үсэг зурагдсан. - “Төслийн удирдах хороо”-ны бүрэлдэхүүнийг батлах тушаалын төслийг боловсруулан, ТЕГ-ын даргын 2017 оны 2 сарын 10-ны өдрийн А36 дугаар тушаалаар батлуулсан. Мөн 2017 оны 3 сарын 16-ний өдрийн ТЕГ-ын даргын А/63 дугаар тушаалаар Төсөл хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүн батлагдсан. - Татварын алба болон ОУВС-ын төслийн нэгжийн үйл ажиллагааны уялдааг хангаж, ОУВС-ын зөвлөхүүдийн шаардлагатай мэдээллийг хүргүүлэх, холбогдох уулзалт хэлэлцүүлэг, сургалтыг зохион байгуулж, шаардлагатай мэдээллээр хангаж, төслийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажилласан.</p> <p>2.Японы ЖАЙКА байгууллага болон Монголын татварын албатай хамтран хэрэгжүүлж буй “Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь” сэдэвт төслийн хүрээнд 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/77 дугаар тушаалаар төслийн удирдах хорооны гишүүд батлагдаж, удирдах хорооны хурлуудыг зохион байгуулж, хурлын талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан. Японы ЖАЙКА байгууллага болон Монголын татварын албатай хамтран</p>

			хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгааг тухай бүр хүргүүлсэн. Төслийн хүрээнд 2015-2016 оны өртэй татвар төлөгчийн тоог татварын алба болон татварын төрлөөр, 2010-2016 оны тайлангаар болон хяналт шалгалтын татварын өрийн дүнг татварын төрлөөр, 2012-2016 оны татварын өрийг барагдуулахад авч хэрэгжүүлсэн татвар хураах шат дараалсан арга хэмжээний мэдээг тус тус гаргаж, суурь судалгааны тайланд холбогдох судалгааг гаргаж хүргүүлсэн. Төслийн багийн зөвлөхөөс ирүүлсэн асуулгын хариу, судалгаа, тодруулга мэдээг хүргүүлсэн. Төлөвлөгөөний сургалтын хуваарийн дагуу олон улсын татвараар мэргэших албан хаагчдад “Олон улсын татварын асуудлаар суурь мэдлэг олгох” сэдэвт сургалтыг 3 удаагийн сургалт зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 127 албан хаагч хамруулсан.
Эрх зүйн үндэслэл:			
<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.1: 			
5	5.1.Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангаж ажиллах	<p>Татварын ерөнхий газар болон харьяа нэгжийн 12 удирдах албан тушаалд Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн сонгон шалгаруулалтыг хийж, үүрэгт ажилд нь томиллоо. Мөн Төрийн албаны зөвлөлд албан хүсэлт хүргүүлэн Нийслэлийн татварын газар, 9 дүүргийн Татварын хэлтсийн даргын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг нээлттэй зарланаас 28 албан хаагч бүртгүүлж, 24 албан хаагч шалгалтад тэнцсэн байна.</p> <p>Татварын албаны хэмжээнд хүний нөөцтэй холбогдолтой албан хаагчдын дэлгэрэнгүй судалгаа, цалингийн судалгаа, орон тооны судалгаа, нөөцөд бүртгэлтэй албан хаагчдын судалгаа, татварын мэргэшсэн нягтлан бодогчийн судалгаа, мэргэшсэн нягтлан бодогчийн судалгаа, тэтгэвэрт гарах албан хаагчдын судалгаа, 16 хүртэл насны хүүхэдтэй албан хаагчийн судалгаа, 2017 онд татварын албаны татварын хяналт шалгалтын нэгжид ажиллаж буй татварын улсын /ахлах/ байцаагчийн судалгаа зэрэг 12 төрлийн судалгаа хийж зарим судалгааг цахим хуудсанд байршуулсан болно.</p>	
Эрх зүйн үндэслэл:			
<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; 6.1.7 			
6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжийг бий		Татварын ерөнхий газрын 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, удирдлагаар батлуулан, Сангийн яаманд хүргүүлсэн. Төрийн

болгож олон нийтэд дараах мэдээллийг түгээж ажиллах	худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn сайтад Татварын ерөнхий газрын 2017 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг оруулж, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл авч баталгаажуулсны үндсэн дээр төсөл арга хэмжээний жагсаалтад худалдан авах ажиллагааг нэг бүрчлэн оруулж, дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулсан.
6.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур, тендерийн урилга	Бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн бичиг баримт бэлтгэн, бараа ажил үйлчилгээний талаар зах зээлийн судалгаа хийсний үндсэн дээр техникийн үзүүлэлт, тодорхойлолтыг бэлтгэж, зураг эскиз гаргах, бараа ажил үйлчилгээг нэр төрөл зориулалтаар нь багцлан, төсөвт багтаан ажлын тоо хэмжээг тооцох, хууль журмын дагуу 10 тендерийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зохион байгуулсан. Хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тендерийн зарыг www.tender.gov.mn , www.mta.mn сайтууд болон "Өдрийн сонин"-оор зарлаж, тендерийн үр дүнг www.tender.gov.mn сайтаар нийтэлсэн.
6.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл болон шалгарсанболон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг жагсаалт	Цахим систем дээр төсөл арга хэмжээ, тендер шалгаруулалтын ерөнхий мэдээлэл, үнэлгээний хорооны болон гишүүдийн мэдээлэл, тендерийн шалгуур үзүүлэлтүүд, хугацаа болон шаардлагатай мэдээллүүдийг tender.gov.mn , shilendans.gov.mn тогтмол байршуулж ажилласан.
6.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг tender.gov.mn , shilendans.gov.mn тогтмол байршуулж ажилласан.
6.5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хяналт, шалгалтын дүн	Худалдан авах ажиллагаандаудитын хийгдээгүй байгаа болно.
6.6. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөлөл оролцуулсан болно
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6: 6.1.11; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1.2: 4.1.17: 4.1.2.7: 	

7	7.1.Байгууллагын ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлж ажиллах,	Татварын албаны албан тушаалын 219 ажлын байрны тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/08, Б/155 дугаар тушаалаар тус тус баталж, мөрдүүлэн ажиллаж байна.
	7.2.Албан хаагчийн нэр, албан тушаал, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	Албан хаагчийн нэр, албан тушаал, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулав.
	7.3.Өргөдөл, гомдол, хүсэлтийг утсаар, цахимаар, бичгээр гэх мэт хэлбэрээр хүлээн авч, бүртгэлийг цахимжуулах, шийдвэрлэсэн талаар цахим сайтаар мэдээллэх	<p>Тайлангийн хугацаанд 2017 онд байгууллагаас явсан 3500 албан бичгийн бүрдлийг шалган дугаар өгч, шуудангаар 2436 албан бичгийг холбогдох газруудад хаяглан явуулав.</p> <p>Татварын ерөнхий газарт 2017 онд 4856 албан бичиг, тогтоол, шийдвэр факс ирснээс хариугүй 2625, хариутай 2231, үүнээс хариу явуулсан 2146 албан бичиг, 85 албан бичиг хугацаа болоогүй. Нийт 16067 хуудас материал скайнердаж оруулсан, нийт 553 өргөдөл хүсэлт ирснээс хариу явуулсан 499 өргөдөл, хугацаа болоогүй 54 өргөдөл байна. үүнээс 18 гомдол ирсэнээс хариу явуулсан 16 гомдлын хариуг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хугацаа болоогүй судлагдаж байгаа 2 гомдол байна.</p>
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2: 		
8	8.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтанг томилж, ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгаж, үйл ажиллаанд хяналт тавьж ажиллах	<p>Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г баталсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн дагуу Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг Татварын ерөнхий газрын үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөний төслийг боловсруулан батлуулж Татварын албадад хүргүүлж үйл хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн Татварын албадын ЭБАТ- нарын хагас, бүтэн жилийн ажлын тайланг авч нэгтгэл хийв.</p> <p>Татварын албадыг <u>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах зөвлөмж хүргүүлэх</u>, "<u>Баталгааны маяг</u>"-ыг <u>авахтай</u> холбогдуулан хуулийн</p>

хэрэгжилтийг хангуулж ажиллах чиглэлээр албан бичгээр 2 удаа, цахим шуудангаар 5 удаа мэдээлэл хүргэж, майл болон утсаар холбогдон зөвлөмж арга зүйгээр хангав.

Татварын албаны хэмжээнд 1393 албан хаагчийн ХАСХОМ-ийн баталгааны маягтыг хуулийн хугацаанд баталгаажууллаа. Баталгааны маягтыг гаргаагүй, хоцроосон албан хаагч байхгүй болно. Татварын албаны ХАСХОМ-н тайлангийн нэгтгэлийг 2017 оны 02 дугаар сарын 24-ний 03/613 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газар хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газарт 2017 оны 01 дүгээр сарын 06-ний 03/45 дугаар албан бичгээр Татварын албаны ЭБАТ нарт сургалт авах хүсэлтийг хүргүүлсэн. Хүсэлтийн хүлээн авч Авлигатай тэмцэх газраас 2017 оны 01 дүгээр сарын 17-18 өдрүүдэд зохион байгуулсан сургалтад ТЕГ, УТОХГ, НТГ, БГД, БЗД, ХУД, СХД, ЧД-ийн Татварын албадын 8 ЭБАТ-ыг хамрагдав. Сургалтаар өгсөн заавар чиглэлийг Орон нутгийн татварын албадад 2017 оны 01 дүгээр сарын 19-ны 03/199 дүгээр албан бичгээр, сургалтын материалын хамт файлаар хүргүүлэв. Мөн Авлигатай тэмцэх газарт 2017 оны 01 дүгээр сарын 30-ний 03/310 дугаар албан бичгээр Татварын албаны удирдах албан тушаалтны сургалт семинарт зориулан Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт авах хүсэлтийг хүргүүлэв. Хүсэлтийг хүлээн авч Авлигатай тэмцэх газраас 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Татварын албаны удирдах албан тушаалтан нарт сургалт хийв.

Татварын албаны удирдах албан тушаал, улсын байцаагчийг сэлгэн ажиллуулах, сонгогдохоор нэр дэвшсэн 60 албан хаагчийн “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”-ийг хуулийн дагуу хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн 60 албан хаагчдад дүгнэлт гаргуулав. Шинээр томилогдсон 74 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авч цахим мэдээллийн санд оруулж баталгаажуулав.

Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн дагуу Татварын ерөнхий газрын авлигын эсрэг үйл

		<p>ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.</p> <p><u>Авлигатай</u> тэмцэх газраас шалган зааварчлах ажлын хэсэг 2017.04.02-07-ны өдрүүдэд Татварын ерөнхий газарт ажиллаа. Ажлын хэсэгт шаардлагатай судалгаа, холбогдох материал болон тайлбарыг гаргаж өгөв.</p>
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.1.12,6.8: • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 7.2.6, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; 		
9	<p>9.1.Татварын ажилтны зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэж, мэдээллийг цахим хуудсанд ил тод байршуулах</p>	<p>Тайлант хугацаанд ёс зүйн зөрчилтэй холбоотой нийт 25 бичиг ирүүлсэнээс иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдол 6, байгууллагын удирдлагын шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулах санал бүхий албан бичиг 19 ирснийг судлан Төрийн албан хаагчийн болон татварын албаны ажилтны ёс зүйн дүрэм зөрчсөн гэж үзэж сахилгын шийтгэл ногдуулахаар ТЕГ-ын даргын 10 тушаалаар 15 ажилтанд сануулах, 31 ажилтанд цалингийн хэмжээг бууруулах, 4 ажилтныг ажлаас халах шийдвэр гаргав. Одоогийн байдлаар сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзсэн 4, гомдлоо буцааж татсан 1 иргэн, албан бичгийг шийдвэрлэхээс өмнө өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 1, харьяалалын дагуу шийдвэрлүүлэхээр аймаг, дүүргийн татварын хэлтэст шилжүүлээд хариу ирүүлээгүй байгаа 5, хянан шалгаж байгаа 4 дүгнэлт байна.</p>
	<p>9.2. Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулан, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаа хийж, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох</p>	<p>Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулан, давхар ажил эрхлэлтийн талаарх татварын албадын нэгдсэн судалгаа хийж нэгтгэл хийв.</p>
	<p>9.3.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах</p>	<p>Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргаж, Ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянаж ажиллав. Нийт сэлгэн шилжүүлсэн 60, шинээр томилогдсон 74 албан хаагч давхардсан тоогоор 134 ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг гаргаж өгсөн болно.</p>
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; • Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.7.3: 		

10	10.1.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах	Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг байгууллагын цахим хуудаст байршуулахаас гадна эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn -нд байршуулсан.
	10.2..Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах	Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээ тогтоосон акт, дотогш чиглэсэн дүрэм, журам, зааврыг цахим хуудаст байршуулсан.
<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4; 		
11	11.1.Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан зөвлөмж, шийдвэрийг биелүүлэх -	<p>Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн дагуу Татварын ерөнхий газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Авлигатай тэмцэх газраас шалган зааварчлах ажлын хэсэг 2017.04.02-07-ны өдрүүдэд Татварын ерөнхий газарт ажиллаа. Ажлын хэсэгт шаардлагатай судалгаа, холбогдох материал болон тайлбарыг гаргаж өгч ажиллав.</p>

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ТАТВАРЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Л.НЭРГҮЙ

П.УНДАРМАА

